

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/77/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: [maitsetsegt@audit.gov.mn](mailto:maitsetsegt@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	16
3.8 Аудитын гол асуудал .....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт.....	19
4.3 Албан шаардлага .....	20
4.4 Зөвлөмж .....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НХМ	Нэг хэвийн маягт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/133  
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ  
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Ч.ГАНЧИМЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант хугацаанд 648,056.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан нь Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын 1.4-д "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэгслийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй ба 47,406.9 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хүнс, шатахуун, бусад материалыг Ковид-19 цар тахлын хүрээнд зарцуулсан нь анхан шатны баримтаар нотлогдохгүй Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5.1.5-д "хариуцлагатай байх", гэсэн заалт, санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

19020421

D 2022/2022 он/ALBAN BICHIG

**Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

**Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>72,634,689.01</b>	<b>73,753,971.02</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>7,759,324.09</b>	<b>8,000,000.00</b>
335	Бусад авлага	7,759,324.09	8,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	7,759,324.09	8,000,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>64,875,364.92</b>	<b>65,753,971.02</b>
351	Түүхий эд материал	-	440,000.00
35130	Эм боох материал	-	440,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>64,875,364.92</b>	<b>57,813,971.02</b>
<b>35410</b>	<b>Бичиг хэргийн материал</b>	<b>4,795,600.00</b>	<b>12,330,900.00</b>
35420	Аж ахуйн материал	42,508,252.52	41,755,062.52
35430	Сэлбэг хэрэгсэл	860,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	12.40	8.50
35470	Бусад хангамжийн материал	16,711,500.00	3,728,000.00
35600	Мал амьтад	-	7,500,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,171,344,695.89</b>	<b>2,411,235,580.63</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,171,344,695.89</b>	<b>2,411,235,580.63</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,128,238,029.19</b>	<b>2,369,022,247.33</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,209,112,912.00	1,284,969,965.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(180,309,986.14)	(238,026,365.74)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	309,582,307.00	419,203,307.00
<b>39204</b>	<b>Хуримтлагдсан элэгдэл</b>	<b>(191,155,300.06)</b>	<b>(218,278,808.82)</b>
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	150,271,814.20	189,438,314.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(77,421,462.14)	(102,777,674.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79,344,568.86	88,041,777.02
<b>39208</b>	<b>Хуримтлагдсан элэгдэл</b>	<b>(42,333,408.14)</b>	<b>(52,500,499.61)</b>
<b>39209</b>	<b>Зам, гүүрийн байгууламж</b>	<b>260,768,479.00</b>	<b>260,768,479.00</b>
39210	Хуримтлагдсан элэгдэл	(107,675,482.32)	(123,041,648.28)
39214	Бусад үндсэн хөрөнгө	902,763,689.96	956,698,832.96
39215	Хуримтлагдсан элэгдэл	(249,118,102.23)	(355,473,430.55)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	64,407,999.20	260,000,000.00
393	Биет бус хөрөнгө	43,106,666.70	42,213,333.30
39301	Програм хангамж	3,780,000.00	3,780,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,577,333.30)	(2,470,666.70)
<b>39303</b>	<b>Бусад биет бус хөрөнгө</b>	<b>40,904,000.00</b>	<b>40,904,000.00</b>
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,243,979,384.90</b>	<b>2,484,989,551.65</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,734,249.80</b>	<b>9,034,309.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,734,249.80</b>	<b>9,034,309.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>7,734,249.80</b>	<b>9,034,309.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,142,249.00	2,143,960.00
4136	Бусад өглөг	5,592,000.80	6,890,349.00
41361	Байгууллагад төлөх өглөг	5,592,000.80	6,890,349.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,236,245,135.10</b>	<b>2,475,955,242.65</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,236,245,135.10</b>	<b>2,475,955,242.65</b>
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын</b>	<b>667,794,348.38</b>	<b>667,794,348.38</b>
<b>51101</b>	<b>Өмч: - төрийн</b>	<b>667,794,348.38</b>	<b>667,794,348.38</b>
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,367,441,992.05</b>	<b>1,607,152,099.60</b>
<b>51210</b>	<b>Өмнөх үеийн үр дүн</b>	<b>1,367,441,992.05</b>	<b>1,367,441,992.05</b>
<b>51220</b>	<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>-</b>	<b>239,710,107.55</b>
<b>51300</b>	<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	<b>201,008,794.67</b>	<b>201,008,794.67</b>
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,243,979,384.90</b>	<b>2,484,989,551.65</b>

**Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	781,832,988.02	1,330,941,658.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	168,759,292.02	120,159,136.00
120	Нийтлэг татварын бус орлого	168,759,292.02	120,159,136.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	168,759,292.02	120,159,136.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	5,381,665.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	163,377,627.02	120,159,136.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	613,073,696.00	1,210,782,522.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,537,096.00	94,919,422.80
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,860,614.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,787,616.00	56,954,833.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,749,480.00	25,103,975.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	580,536,600.00	1,115,863,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	580,536,600.00	1,115,863,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	744,659,324.18	1,013,229,981.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	717,686,625.98	872,192,858.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	671,880,924.05	831,659,854.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,127,553.00	239,352,888.00
210101	Үндсэн цалин	166,976,756.00	154,352,540.00
210102	Нэмэгдэл	23,988,121.00	41,423,892.00
210105	Гэрээт ажлын хөлс	40,162,676.00	43,576,456.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,857,831.00	33,740,483.93
210201	Тэтгэврийн даатгал	21,954,561.00	24,348,760.26
210202	Тэтгэмжийн даатгал	2,442,925.00	2,441,545.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,928,438.00	1,916,276.99
210204	Ажилгүйдлийн даатгал	479,886.00	449,744.99
210205	Эрүүл мэндийн даатгал	3,052,021.00	4,584,155.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,690,248.38	70,083,619.91
210301	Гэрэл, цахилгаан	8,684,948.38	9,829,520.91
210302	Түлш, халаалт	52,865,300.00	50,462,624.00
210303	Цэвэр, бохир ус	140,000.00	9,791,475.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,002,285.30	44,050,703.91
210401	Бичиг хэрэг	4,830,850.00	4,863,820.38
210402	Тээвэр, шатахуун	19,049,135.30	32,331,383.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,122,300.00	5,545,889.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	-	1,309,610.00
2105	Нормативт зардал	-	89,421,890.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	47,221,240.00
210502	Хоол, хунс	-	25,095,340.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	17,105,310.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,140,000.00	5,918,589.00
210604	Урсгал засвар	1,140,000.00	5,918,589.00
2107	Томилолт, зочны зардал	3,661,000.00	1,958,000.00
210702	Дотоод албан томилолт	3,661,000.00	1,958,000.00

**Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	9,172,648.00	13,988,394.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	7,525,620.00	12,654,150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	645,600.00	582,144.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	323,320.00	335,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	358,108.00	416,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	307,229,358.37	333,145,286.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,127,167.09	85,617,255.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	104,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	240,102,191.28	247,424,031.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,805,701.93	40,533,003.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,896,300.00	1,300,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,816,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,080,000.00	1,300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас	26,909,401.93	39,233,003.44
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,909,401.93	39,233,003.44
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,972,698.20	141,037,122.80
2200	Дотоод эх үүсвэрээр	26,972,698.20	141,037,122.80
220001	Барилга байгууламж	9,823,729.60	-
221001	Их засвар	17,170.00	25,515,400.00
223001	Бусад хөрөнгө	17,131,798.60	115,521,722.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	37,173,663.84	317,711,677.65
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,617,039.59	78,001,570.10
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,050,339.59	69,854,380.10
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	566,700.00	8,147,190.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,617,039.59)	(78,001,570.10)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	35,556,624.25	239,710,107.55

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	667,794,348.38	202,477,303.04	1,137,236,649.32	2,007,508,300.74
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	667,794,348.38	202,477,303.04	1,137,236,649.32	2,007,508,300.74
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	183,798,881.28	183,798,881.28
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	667,794,348.38	201,008,794.67	1,367,441,992.05	2,236,245,135.10
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	667,794,348.38	201,008,794.67	1,367,441,992.05	2,236,245,135.10
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	667,794,348.38	201,008,794.67	1,367,441,992.05	2,236,245,135.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	239,710,107.55	239,710,107.55
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	667,794,348.38	201,008,794.67	1,607,152,099.60	2,475,955,242.65

**Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	618,455,361.00	1,210,782,522.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,381,665.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	5,381,665.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,381,665.00	-
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	5,381,665.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	613,073,696.00	1,210,782,522.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,537,096.00	94,919,422.80
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	-	12,860,614.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан	11,787,616.00	56,954,833.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	20,749,480.00	25,103,975.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	580,536,600.00	1,115,863,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	580,536,600.00	1,115,863,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	515,493,170.60	499,431,529.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	515,493,170.60	499,431,529.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	469,647,468.67	458,898,525.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,771,765.00	239,352,888.00
210101	Үндсэн цалин	165,678,785.00	154,352,540.00
210102	Нэмэгдэл	23,988,121.00	41,423,892.00
210105	Гэрээт ажлын хөлс	40,104,859.00	43,576,456.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,421,217.29	31,460,315.64
210201	Тэтгэврийн даатгал	21,658,685.53	22,136,770.38
210202	Тэтгэмжийн даатгал	2,365,796.19	2,351,053.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,877,234.55	1,881,222.20
210204	Ажилгүйдлийн даатгал	477,050.27	457,919.59
210205	Эрүүл мэндийн даатгал	3,042,450.75	4,633,350.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,535,248.38	70,063,619.91
210301	Гэрэл, цахилгаан	9,704,948.38	9,829,520.91
210302	Түлш, халаалт	52,690,300.00	50,222,624.00
210303	Цэвэр, бохир ус	140,000.00	10,011,475.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,098,600.00	31,071,989.01
210401	Бичиг хэрэг	5,300,700.00	4,596,820.38
210402	Тээвэр, шатахуун	18,907,500.00	19,123,379.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,890,400.00	5,353,989.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	-	1,997,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	3,499,589.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	3,499,589.00
2107	Томилолт, зочны зардал	3,661,000.00	1,958,000.00
210702	Дотоод албан томилолт	3,661,000.00	1,958,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	18,822,144.00	14,099,528.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	17,175,116.00	12,160,484.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	645,600.00	582,144.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	323,328.00	335,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	358,100.00	416,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,337,494.00	67,392,596.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	97,337,494.00	67,288,596.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	104,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,845,701.93	40,533,003.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,936,300.00	1,300,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,816,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,120,000.00	1,300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	26,909,401.93	39,233,003.44
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,909,401.93	39,233,003.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	102,962,190.40	711,350,993.80
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	102,962,190.40	711,350,993.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	102,962,190.40	711,350,993.80
2200	Дотоод эх үүсвэрээр	102,962,190.40	711,350,993.80
220001	Барилга байгууламж	69,458,391.00	-
221001	Их засвар	-	45,330,650.00
223001	Бусад хөрөнгө	33,503,799.40	197,622,043.80
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	468,398,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(102,962,190.40)	(711,350,993.80)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-

**Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	534,118,700.00	448,476,566.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	534,118,700.00	448,476,566.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	533,118,700.00	447,476,566.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,659,200.00	239,352,888.00
210101	Үндсэн цалин	157,251,500.00	154,352,540.00
210102	Нэмэгдэл	40,713,000.00	41,423,892.00
210105	Гэрээт ажлын хөлс	42,694,700.00	43,576,456.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,489,200.00	31,460,315.64
210201	Тэтгэврийн даатгал	22,862,700.00	22,136,770.38
210202	Тэтгэмжийн даатгал	2,406,600.00	2,351,053.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,925,300.00	1,881,222.20
210204	Ажилгүйдлийн даатгал	481,400.00	457,919.59
210205	Эрүүл мэндийн даатгал	4,813,200.00	4,633,350.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,673,600.00	60,301,144.91
210301	Гэрэл, цахилгаан	12,703,700.00	9,829,520.91
210302	Түлш, халаалт	54,720,000.00	50,222,624.00
210303	Цэвэр, бохир ус	249,900.00	249,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,033,300.00	31,071,989.01
210401	Бичиг хэрэг	4,600,900.00	4,596,820.38
210402	Тээвэр, шатахуун	19,127,000.00	19,123,379.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,305,400.00	5,353,989.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,997,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,499,589.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,499,589.00
2107	Томилолт, зочны зардал	5,514,500.00	1,958,000.00
210702	Дотоод албан томилолт	5,514,500.00	1,958,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,083,900.00	3,439,044.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	5,000,000.00	1,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	645,600.00	582,144.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	416,700.00	335,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	416,800.00	416,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	146,165,000.00	78,393,596.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	146,165,000.00	78,393,596.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	848,592,000.00	648,055,993.80
2200	Дотоод эх үүсвэрээр	848,592,000.00	648,055,993.80
220001	Барилга байгууламж	300,000,000.00	240,000,000.00
221001	Их засвар	226,381,900.00	64,641,750.00
223001	Бусад хөрөнгө	322,210,100.00	343,414,243.80
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,382,710,700.00	1,115,863,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,382,710,700.00	1,115,863,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	1,382,710,700.00	1,115,863,100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27.00	27.00
620001	Удирдах ажилтан	6.00	6.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00

**Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	75,016,959.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,007,116.00	75,016,959.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,007,116.00	74,716,959.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	9,762,475.00
210303	Цэвэр, бохир ус	-	9,762,475.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,000,000.00
210604	Урсгал засвар	-	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,787,616.00	10,660,484.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,787,616.00	10,660,484.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,219,500.00	52,294,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,219,500.00	52,190,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	104,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	300,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	29,007,116.00	94,919,422.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29,007,116.00	94,919,422.80
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,860,614.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,787,616.00	56,954,833.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,219,500.00	25,103,975.00
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газар нь бүх шатны Хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр, засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

Тус байгууллага нь сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн А/22 дугаар захирамжаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталгаажуулсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсронгуй болгох нь зүйтэй байна.

Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газар нь дотоод хяналт хэрэгжүүлэх журам, заавар боловсруулж мөрддөг эсэх гэсэн асуулгад Засгийн газрын 311 дүгээр тогтоолыг үндэслэн Тамгын газрын дотоод журам болон бусад хууль эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн үйл ажиллагаа явуулдаг тусгайлан батлуулж мөрддөг журам заавар байхгүй гэж ирүүлсэн ба дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө, тайлан аудитад ирүүлээгүй болно. Засгийн газрын 2011 оны "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" батлах тухай тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас тус байгууллагын 2021 оны тусгай сангуудын үйл ажиллагаанд болон 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна. Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг 27 сумдад хийж, зөвлөн туслах хяналт хийдэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Мөнгөнморьт сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Мөнгөнморьт сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлаас 1,5 хувиар буюу 7,732.4 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,799.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг өмнөх оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зардлаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зардлаас 1,5 хувиар буюу 18,161.7 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13,621.3 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 10,429.3 мянган төгрөгөөр өссөн байна.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

**Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:**

Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 онд орон нутгийн төсвөөс 1,115,863.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, нэмэлт санхүүжилтийн дансанд 94,919.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн ба мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 1,210,782.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:**

Үндсэн хөрөнгө дансанд төсвийн хөрөнгөөр 468,398.3 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээс 88,771.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 64,408.0 мянган төгрөгийн дуусаагүй барилгын оны эхний үлдэгдлийг барилга ашиглалтад орсон тул шилжүүлэн, мөн сумын ИТХ-ын шийдвэрээр 6,294.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,597.7 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг шилжүүлэн бүртгэсэн байна.

Бараа материал дансанд төсвийн хөрөнгөөр 170,004.8 мянган төгрөгийн, хандив бусад эх үүсвэрээр 31,388.1 мянган төгрөгийн орлогоор бүртгэж, зарцуулсан байна.

**Авлага, өглөгийн талаар:**

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Батсүмбэр толгойн Сүхбаатарын хөшөөг тохижуулах ажлын урьдчилгаанд олгосон 8,000.0 мянган төгрөгийн ажлыг дуусгаагүй тул авлагаар, ажиллагчидтай холбоотой 2,143.9 мянган төгрөг, байгууллагад өгөх 6,890.4 мянган төгрөг, нийт 9,034.3 мянган төгрөгийн өглөгийг тайлагнасан байна.

**Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар мөнгөн хөрөнгө 00 төгрөгийн, авлага 8,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бараа материал 65,754.0 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 2,411,235.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	1.0	2.0	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	7,759.3	8,000.0	240.7
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	64,875.4	65,754.0	878.6
Үндсэн хөрөнгө	2,171,344.7	2,411,235.6	239,890.9
Нийт хөрөнгө	2,243,979.4	2,484,989.6	241,010.2
Өр төлбөр	7,734.2	9,034.3	1,300.1
Засгийн газрын оролцоо	2,236,245.1	2,475,955.2	239,710.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,243,979.4	2,484,989.6	241,010.2

Бараа материалын дансны үлдэгдэл 65,754.0 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 878.0 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын үлдэгдлээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,411,235.6 мянган төгрөг болж 239,890.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 557,169.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,475,955.2 мянган төгрөг болж 239,710.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 513,965.9 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн 2021 оны төсвийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Засаг даргын Тамгын газрын төсвийг 517,723.7 мянган төгрөгөөр баталж, хүргүүлсэн төсвийн төслийг 3,757.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Мөн сумын төсвийн шилжих үлдэгдэл 5,592.0 мянган төгрөг, 2021 оны давсан орлогоос хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын 793,000.0 мянган төгрөг, нийт 798,592.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталсан байна. Сумын 2021 оны төсвийн батлагдсан төлөвлөгөөнд сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 03 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулан баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар орон нутгийн төсвөөс 1,115,863.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаандаа 448,476.6 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 648,056.0 мянган төгрөг, нийт 1,096,532.6 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 19,330.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 03 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулан 1,316,315.7 мянган төгрөгөөр баталсан дүнгээс аймгийн СТСХ-ийн зарцуулах эрхийг Сангийн Яамнаас нээлгэсэн 1,382,710.7 мянган төгрөгөөс 66,395.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байсанд төлөвлөгөөнд нийцүүлэн залруулга хийсэн болно.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,096,532.6 мянган төгрөг буюу 98,3 хувьтай хэрэгжсэн байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 417-р ангийн санхүүжилт 10,000.0 мянган төгрөг, бярваазын санхүүжилт 39,890.3 мянган төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамтарсан багийн санхүүжилт 300.0 мянган төгрөг, өвс тэжээлийн орлого 14,518.6 мянган төгрөг, Ковидтай холбоотой хандив 2,240.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын А/518 дугаар захирамжаар 5,000.0 мянган төгрөг, А/72 дугаар захирамжаар 1,000.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 8,047.6 мянган төгрөг, Засгийн газраас олгосон усны төлбөрт 9,703.8 мянган төгрөг, цахим тендерийн 105.0 мянган төгрөг, хагас жилийн мал тооллогын санхүүжилт 660.5 мянган төгрөг, үнэт цаас хуудасны үнэ 867.6 мянган төгрөг, санхүүжилт гэж 2,274.7 мянган төгрөг, СХС-ийн андуурсан гүйлгээ 101.2 мянган төгрөг, нийт 94,709.4 мянган төгрөг төвлөрсөн ба СХС-

ийн андуурсан гүйлгээ 101.2 мянган төгрөгийг өглөгөөр бүртгээгүй, 210.0 мянган төгрөгийн орлогыг бууруулах бичилт хийсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас худаг усны зардалд 9,977.5 мянган төгрөг, 417-р ангийн санхүүжилт 10,000.0 мянган төгрөг, Бярвааз засварлах ажлын зардалд 37,000.0 мянган төгрөг, ГХУС багийн үйл ажиллагааны зардалд 300.0 мянган төгрөг, өвс тэжээлийн үнэнд 7,175.0 мянган төгрөг, хагас жилийн мал тооллогын урамшуулалд 660.5 мянган төгрөг, Ковидын ариутгалын зардалд 3,051.0 мянган төгрөг, Статистикийн 3 багийн Засаг дарга нарын сургалтын зардалд 104.0 мянган төгрөг, Био 00-ын үнэнд 1,949.0 мянган төгрөг, 2020 оны урианы жилийн шагналд 300.0 мянган төгрөг, баримтын шалгалтын актын төлбөр барагдуулалт 4,500.0 мянган төгрөг, нийт 75,016.9 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 19,902.5 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Мөнгөнморьт сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 03 дугаар тогтоолоор төсвийн шилжих үлдэгдэл 5,592.0 мянган төгрөг, 2021 оны давсан орлогоос 793,000.0 мянган төгрөг, нийт 798,592.0 мянган төгрөгийн хөрөнгийн зардалд зарцуулахаар баталж дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын 1.4-д” энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэгслийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна. Үүнд:

- Сумын Цагдаагийн автомашин шинээр авахад 28,900.0 мянган төгрөг, цагдаагийн драгер үлээгчийг 2,921.6 мянган төгрөг, ЕБС-ийн хими, дуу хөгжмийн кабинет тохижуулах ажилд 11,320.0 мянган төгрөг, Цэцэрлэгийн өргөтгөлийн дулааны холболтын ажилд 19,402.0 мянган төгрөг, Ойн ангийн дулааны холболтын урьдчилгаанд 6,590.0 мянган төгрөг,
- Хогийн цэг түрж булах авто механизм авахад 80,721.0 мянган төгрөг, үерийн далангийн ажилд 260,000.0 мянган төгрөг, Батсүмбэр толгойн Сүхбаатарын хөшөөг тохижуулах ажлын 80 хувийн урьдчилгаанд 8,000.0 мянган төгрөг, Тариалангийн хоорондын бэлчээрийн газраас тариалангийн газарт шилжүүлэх агрохими, агрофизикийн шинжилгээ хийлгэх ажилд 5,000.0 мянган төгрөг, малын ялган тэмдэгжүүлэгчийн үнэ 4,000.0 мянган төгрөг, пос төхөөрөмжийг 1,000.0 мянган төгрөг,
- Сумын ЗДТГ нь ковид-19 цар тахлын хүрээнд 10,969.5 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, 3,344.1 мянган төгрөгийн аж ахуйн материал, 11,410.0 мянган төгрөгийн шатахуун, 20,459.3 мянган төгрөгийн хоол хүнсний материал, 106.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 90.9 мянган төгрөгийн утасны нэгж, 480.0 мянган төгрөгийн гэрлийн утас нийт 47,406.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- Сумын Эрүүл мэндийн төвд био химийн анализатор авахад 10,000.0 мянган төгрөг, иж бүрэн тоноглогдсон автомашинд 34,000.0 мянган төгрөг, хүчилтөрөгчийн аппаратыг 1,500.0 мянган төгрөг, тус төвд шинээр ирсэн фургон машины доторлогоонд 2,850.0 мянган төгрөг, нийт 49,587.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хүнс, аж ахуйн материал олгосон байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын бараа материалын данснаас 44,234.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, 4,120.6 мянган төгрөгийн хоол хүнсний материал, 1,232.9 мянган төгрөгийн тусгай дуут дохио, аж ахуйн бусад материал, нийт 49,587.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, эд зүйлсийг сумын Эрүүл мэндийн төвд шаардах хуудсаар

олгож, шилжүүлснийг зарцуулснаар, Тамгын газар нь бараа материалын данснаас 10,969.5 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, 3,344.1 мянган төгрөгийн аж ахуйн материал, 11,410.0 мянган төгрөгийн шатахуун, 20,459.3 мянган төгрөгийн хоол хүнсний материал, 106.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 90.9 мянган төгрөгийн утасны нэгж, 480.0 мянган төгрөгийн гэрлийн утас нийт 47,406.9 мянган төгрөгийг ковид цар тахлын хүрээнд зарцуулсныг зөвхөн шаардах хуудсаар зардалд бичсэн нь анхан шатны баримтгүй, нотлогдохгүй байна.

Сумын Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн А/83 дугаар захирамжаар иргэдээс авах түргэвчилсэн оношлуурын үнийг 25000 төгрөгөөр тогтоож, орлогыг сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн 100141555408 тоот дансанд төвлөрүүлэхийг үүрэг болгосон боловч нэг ч төгрөгийн орлого төвлөрөөгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 4 мэдээлэл хугацаа хоцроосон, 2 мэдээллийг байршуулаагүй төлөвтэй боловч, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байршуулаагүй, сумын Засаг даргаар баталгаажуулж албажуулаагүй сумын нэгдсэн төлөвлөгөөг байршуулсан, худалдан авах ажиллагааны тайланг мөн байршуулаагүй байна.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тухай бүр байршуулахыг 5.0 сая төгрөгөөс доош үнийн дүн бүхий гүйлгээг байршуулсан, шийдвэрийн хуулбарыг байршуулж мэдээлдэггүй байна.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг байршуулах хэсэгт мэдээллийг бүрэн байршуулаагүй ба дараах ажил үйлчилгээ гэрэл цахилгаан, түлш халаалт, тээвэр шатахуун, шуудан холбооны зардлын гүйлгээг 6 сараас хойш огт байршуулаагүй ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн дүнтэй тулгахад 48,508.0 мянган төгрөгийн мэдээлэл байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй ба санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй ба өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29-р тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д нийцүүлэн мэдээллийг иж бүрэн, ойлгомжтой мэдээлэх гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 06/319 тоот албан бичгээр ирүүлсэн боловч зөрчил таслан зогсоогүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд аудит хийх явцад тайлант онд төсвийн шилжих үлдэгдэл, давсан орлогоос хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлыг хугацаандаа дуусгаж хүлээлгэн өгөөгүй болон хөрөнгийн зардалд урсгал зардлыг төлөвлөн зарцуулж байгаа зөрчилд дараагийн аудитаар анхаарал татахуйц байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 831,328.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 455,045.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,199.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 371,432.6 мянган төгрөгийн албан шаардлага, 1,651.6 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

### **4.1 Залруулсан алдаа**

Санхүүгийн тайлангийн уялдаа, бүрэлдэхүүнийг шалгахад шалгах баланс 7,072.2 мянган төгрөгөөр зөрүүтэй, 151,354.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр бэлтгэж тайлагнасан зардлыг Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлаар тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.5-д “хариуцлагатай байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аймгийн Онцгой байдлын газраас ирүүлсэн витаминь болон хүнсний багц 1,075.0 мянган төгрөгийг орлогоор бүртгээгүй, тайлант онд төсвөөс бэлтгэсэн үерийн далангийн ажлын

урьдчилгаанд 260,000.0 мянган төгрөг, 75-р гал унтраах ангид тоног төхөөрөмж, засвар зардалд 8,944.2 мянган төгрөг, Батсүмбэр толгойн Сүхбаатарын хөшөөг тохижуулах ажлын урьдчилгаанд 8,000.0 мянган төгрөг тус тус шилжүүлснийг данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” 5.1.5-д “хариуцлагатай байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 6,000.0 мянган төгрөгөөр бэлтгэсэн Ойн менежментийн төлөвлөгөө, 10,000.0 мянган төгрөгийн ус цэвэршүүлэх төхөөрөмж, 2,600.0 мянган төгрөгийн био жорлон зэргийг бараа материалын дансанд буруу ангилан бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.5-д “хариуцлагатай байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

#### 4.2 Төлбөрийн акт

Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвд үхрийн мах 14500 төгрөгөөр 150 кг буюу 2,175.0 мянган төгрөг, аарц 4000 төгрөгөөр 6 кг 24.0 мянган төгрөг, нийт 2,199.0 мянган төгрөгийн бараа материалыг шаардах хуудсаар олгож, зардалд бичсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.2-д “төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын

“толилуулга”, “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.1-д “төрийн өмч, хөрөнгийг үндэслэлгүйгээр бусдад хандивласан, үнэ төлбөргүй шилжүүлсэн” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын А/72 дугаар захирамжаар 1,000.0 мянган төгрөгийг эм, эмнэлгийн хэрэгсэлд зориулан ирүүлснийг зарцуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

### **4.3 Албан шаардлага**

Мөнгөнморьт сумын ЗДТГ-ын жилийн эцсийн санхүүгийн тайланд Батсүмбэр толгойн Сүхбаатарын хөшөөг тохижуулах ажлын урьдчилгаанд олгосон 8,000.0 мянган төгрөгийн ажлыг дуусгаагүй тул авлагаар бүртгэсэн ба ХАОАТ-ын 2,143.9 мянган төгрөг, байгууллагад өгөх 6,890.4 мянган төгрөг, нийт 9,034.3 мянган төгрөгийн өглөгийг тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7-д “авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Тариалангийн хоорондын бэлчээрийн газраас тариалангийн газарт шилжүүлэх агрохими, агрофизикийн шинжилгээ хийлгэх ажлын 80%-ийн урьдчилгаанд ХААИС-д 4,000.0 мянган төгрөг шилжүүлснийг авлагаар бүртгээгүй, Саунд мюзик ХХК-д 5660.0 мянган төгрөгийг давхар шилжүүлсэн гүйлгээг хөрөнгийн зардалд бичсэн алдааг болон ХААИС-д 1,000.0 мянган төгрөг, Өв менежмент ХХК-ний 4,660.0 мянган төгрөгийг бууруулан бичсэн алдааг аудитын явцад алдааг залруулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Анхан шатны баримтын бүрдүүлэлтийг харилцагч байгууллагын НӨАТ-ийн цахим төлбөрийн баримттай тулган шалгахад 308,230.3 мянган төгрөгийн гүйлгээ тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдалд” албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Анхан шатны баримттай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Сумын Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны “Төрийн албан хаагчдад илүү цагийн цалин хөлс олгох тухай” б/09 дугаар захирамжийн дагуу 1,651.6 мянган төгрөгийн илүү цагийг олгохдоо нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг баталгаажуулаагүй, эргүүл постод ажилласан хуваар, гүйцэтгэл нотлох баримтгүйгээр олгосон байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” 5.1.5-д “хариуцлагатай байх”, Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасан заалттай нийцэхгүй байна.

###### **Өгсөн зөвлөмж:**

Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасан дагуу нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг баталгаажуулах ба холбогдох баримтыг бүрдүүлж байх

##### **2. Анхан шатны баримттай холбоотой асуудал**

###### **2.1. Илрүүлэлт:**

Хөрөнгийн тооллого, тооцоо бодолт, өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагын хэрэгжилтийг шалгахад Тооллогын комисс нь хөрөнгийн тооллогыг хийж, үр дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан баримт тэмдэглэл байхгүй, Эд хөрөнгийн тооллогын бүртгэл НХМаягт БМ-8-аар хөрөнгийн чанар байдлыг бичиж, данс бүрээр хөтлөөгүй, өвс тэжээлийн

**Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

тооцоог хугацаанд боддоггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” 5.1.5-д “хариуцлагатай байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Хөрөнгийн тооллого, тооцоо бодолтыг цаг хугацаанд нь чанартай, үнэн зөв хийж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	ЗДТГ	11	831,328.7	3	455,045.5	2	2,199.0	4	371,432.6	2	1,651.6

